



АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИД ХУРАЛДЛАА



Аймгийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн хуралдаан 2015 оны 09-р сарын 25-ны хурлаар дараахь 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

1. Сум хөгжүүлэх сангийн 2013, 2014 оны аудитын тайланг хэлэлцэж удирдлага зохион байгуулалтыг сайжруулах талаар шийдвэр гаргах
2. Төсөвт өөрчлөлт оруулах тухай
3. Б.Бат-Эрдэнэ захиралтай “Эрийн таван тэнгэр” ХХК-д худалдсан тоосгоны үйлдвэрийн тоног төхөөрөмжийг буцаах хүсэлтийг шийдвэрлэх
4. Аймгийн ИТХ-ын 2008.10.07-ны өдрийн А/106 тоот тогтоол хүчингүй болгох тухай
5. “Чандмань-Увс” ХХК-ны дүрмийг батлах тухай
6. Орон нутгийн өмчийн асуудал


ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

“Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулинд өөрчлөлт оруулах санал авах тухай хэлэлцүүлэг



Аймгийн ИТХ-ын “Иргэдийн оролцоо” хуралдааны танхимд болж өнгөрлөө. Хэлэлцүүлэг нь саяхан болж өнгөрсөн “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхыг хөгжүүлэх, эрх зүйн орчныг сайжруулах нь” сэдэвт баруун бүсийн чуулганы үеэр хэлэлцэгдсэн хуулийн төслийг дахин сайжруулах, боловсронгуй болгох талаар санал авсан бөгөөд хэлэлцүүлэгт НӨУБ, аймаг сумын ИТХ-д олон удаа сонгогдсон төлөөлөгчид, Аймгийн ЗДТГ-ын хэлтсийн дарга, аймгийн хэлтэс, газрын дарга нар оролцож өөрсдийн саналаа хэллээ.

“НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ САЙЖРУУЛАХ НЬ” СЭДЭВТ БАРУУН БҮСИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ



Тус бүсийн чуулганд УИХ-ын гишүүн, Төрийн Байгуулалтын Байнгын Хорооны дарга А.Бакей, УИХ-ын гишүүн М.Батчимэг, Засаг Захиргааны Нэгж Түүний Удирдлагын Тухай Хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгааны багийн зөвлөх, Үндсэн Хуулийн Цэцийн гишүүн Д.Ганзориг, НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр зэрэг олон улсын байгууллагын төлөөлөл болон Монголын Нутгийн Удирдлагын Нийгэмлэгийн Гүйцэтгэх захирал Ц.Батгэрэл, сургалт хөтөлбөр гадаад харилцаа хариуцсан ажилтан М.Туяа нар оролцов. Увс аймгаас Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, ИТХ-ын нарийн бичгийн дарга Х.Төртөгтох, ИТХ-ын төлөөлөгч Т.Эрдэнэбат, Б.Гомбосүрэн, Л.Арцанхүү, Улаангом сумын ИТХ-ын дарга Б.Жавхлантөгс, Улаангом сумын ИТХ-ын төлөөлөгч Ё.Мөнхзул нар оролцлоо.

УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДДЭГСДИЙН ДУРСГАЛЫГ ХҮНДЭТГЭХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЛЭЭ

Монгол улсын нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн дагуу улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг 20 дахь удаагаа улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлээ. Энэ өдөр Монголын төр, улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн олон мянган иргэдийнхээ дурсгалыг хүндэтгэж, хэлмэгдлийн хор уршгийг олон түмэнд ойлгуулж таниулах хамгийн гол нь түүхийн хар толбо болсон бусармаг үйлдэл давтагдахаас сэргийлэхэд чиглэгдсэн тодорхой ажил зохион байгуулж, хэлмэгдсэн хүмүүсийн үр хүүхэд, ач зээ нарт хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. Увс аймгийн хувьд 1464 хүн хэлмэгдсэн болох нь тогтоогдож цагаатгагдсан байдаг ба эдгээрээс 1096 хүнийг нь цаазлан хороосон байна. Бусад хүмүүсийг нь хорих, ажил албан тушаалаас нь бууруулах, ажлаас халах, намаас хөөх, эд хөрөнгө хураах зэргээр хэлмэгдүүлж байжээ.



байгуулж тэргүүлсэн сурагчдыг шагнаж урамшууллаа.

Энэхүү өдөрт зориулан Увс аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчдийн дунд зохион байгуулсан “Улс төрийн хэлмэгдүүлэлт-Увс аймагт” сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг Улаангом сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, аймгийн боловсрол соёлын газартай хамтран зохион

МАРШАЛ Ю.ЦЭДЭНБАЛЫН МЭНДЭЛСНИЙ 99 ЖИЛИЙН ОЙ БОЛЛОО.

9-р сарын 17-нд Монголын төр нийгэм цэргийн нэрт зүтгэлтэн, Улсын баатар, Хөдөлмөрийн баатар маршал Юмжаагийн Цэдэнбалын мэндэлсний 99 жилийн ойг тохиолдуулан Увс аймгийн удирдлагагууд, “Юмжаагийн Цэдэнбалын гал голомт” ТББ, Ю.Цэдэнбал академи эрдэм судлалын төв, нутгийн ард иргэд нь түүний хөшөөнд цэцэг өргөн хүндэтгэл үзүүллээ.



Мөн “Ю.Цэдэнбал өчигдөр, өнөөдөр” уулзалт хэлэлцүүлгийг Цэдэнбал судлалын академи болон “Юмжаагийн Цэдэнбалын Гал Голомт” хөдөлгөөнөөс аймгийн холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулав. Энэхүү арга хэмжээнд оролцохоор Улаанбаатар хотоос Түүхийн ухааны доктор Ц.Жамбалсүрэн, залуу судлаач Б.Болд-Эрдэнэ нарын хүмүүс хүрэлцэн ирлээ.



ӨМНӨГОВЬ СУМ :

2015-09-08-ны өдрийн 1000 цагт Дамчаа ренчин Додь гуулин хийд дээр байгууллагын дарга эрхлэгч нар болон иргэдийн төлөөлөл очиж Сумын ИТХ-ын дарга Б.Цэрэнпил Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэгийн



дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан хэлмэгдэгсдэд хүндэтгэл илэрхийлж цугларсан иргэдэд "Улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний хор холбогдол, хэлмэгдэгсдийг цагаатгахын учир" сэдвээр мэдээлэл хийлээ. Уг хийдэд хэлмэгдэгсдэд зориулж ерөөл авахуулж, буяны ном айлдууллаа. Энэ арга хэмжээнд нийт 62 иргэн оролцов.



Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар 9 сарын 2-нд Орлогын голд сумын Засаг дарга, БОБайцаагч, Аймгийн МХГазрын дарга, мэргэжилтэн, байцаагч, Үндэсний телевизийн сэтгүүлч, Цагдаагийн хэсгийн хэсгийн төлөөлөгч нартай

хамтран нэг өдрийн арга хэмжээг зохион байгуулж үйл ажиллагаатай нь танилцан цаашид зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулахгүй байх талаар зөвлөмж анхааруулга өглөө.

Гудамж талбай, тоглоомын газрууд, архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг болон түүгээр үйлчилдэг газруудын үйл ажиллагаанд хяналт тавьж давхардсан тоогоор 28 аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хэвийн үйл ажиллагааг шалгаж ЗХТХ, АСТТХ, ГХУСТХ болон ТХТХ-ийг сурталчилж ажилласан.

САГИЛ СУМ:

- Сумын ГХУС өсвөрийн зөвлөлийг хүлээн авч уулзаж гэмт хэргийн талаар харилцан санал солилцов.
- Сумын ГХУС ажлын хүрээнд цагдаагийн хэсэгтэй хамтран "Тамхины хор уршиг" нэг сарын аяны хүрээнд нэг дэлгүүрээс 190 ширхэг тамхи хураан авч, зохих арга хэмжээ авахуулав.
- Хилийн цэргийн тагнуулын албатай хамтран хилийн бүс дагуух Баянзүрх, Боршоо багийн айлуудаар малын хулгайн гэмт хэргийн талаар сурталчилгаа хийв.

БӨХМӨРӨН СУМ:

Тэргүүлэгчдийн хуралдаанаар Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн сумын дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг авч хэлэлцээд сумын ИТХ-ын ээлжит хуралдаанаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.



Мөн сумын ЗДТГ-ын авто машины бичиг баримтын бүрдэл дутуу учир дахин бэлтгэж хуралдаанд оруулж ирэхийг үүрэг болгож, сумын сургуулийн нам даралтын хралаалтын зууцыг Наранбулаг суманд шилжүүлэх талаарх асуудлыг хэлэлцэж аймгийн ИТХ-д уламжиллаа. Мөн ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн 2015 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хамтарсан хуралдаанаар Хар алтат багийн нутагт үйл ажиллагаа явуулж буй нүүрсний уурхайнуудын хүнд даацын авто машинуудыг нэгдсэн нэг замаар явуулах шийдвэр гаргасан. Энэ нь ажлын явцын талаар сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тус өдрийн хуралдаанаар авч хэлэлцээд "Нэг зам төсөл"-ийн хэрэгжилтийн гүйцэтгэл 100 хувь амжилттай хэрэгжсэн гэж үзлээ. Цаашид замын трас, болон шуудуу зөрчиж машин явуулахгүй байх тал дээр анхаарч ажиллахыг Засаг даргад үүрэг болголоо.

ЗАВХАН СУМ:

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэж ,ИТХ-ын дарга С.Өлзийдэмбэрэл нээж үг хэлэв. Энэ арга хэмжээнд 150 гаруй хүн оролцсон. Дурсгалын зураг татуулсан.Иргэний танхимд хэлмэгдэгсдийн хамаатан садангуудыг хүлээн авч гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлэхэд төсвөөс 200.0 гаруй мянган төгрөг зарцуулсан.



Сумын ИТХ-ын Тэргүүлэгчид 2015.09.23-нд хуралдаж, 4 асуудал хэлэлцсэн. Хурлын хуралдааны ирц 54.7% . Хэлэлцсэн асуудлууд:

- 1.МАН-н салбарын болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэлийг хангах тухай
- 2.Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах, нийтлэг журам батлах тухай.
- 3.Тендерийн бичиг баримт борлуулсны орлогыг зарцуулах журам баталсан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны А/05 дугаар тогтоолыг хүчингүй болгох тухай.
- 4.Сумын Ахмадын сан бүрдүүлэх, зарцуулах журамд өөрчлөлт оруулах тухай асуудлуудыг хэлэлцэж, Тэргүүлэгчдийн 3 тогтоол батлав. Санал шүүмжлэл 7 гарсан. Сумын Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах нийтлэг журмын төслийг тэргүүлэгчид хэлэлцээд Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаал, Төсвийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Засаг даргын нөөц хөрөнгийг захиран зарцуулах боломжтой гэж үзэж тусгайлан журам батлах шаардлагагүй гэдэг дээр тэргүүлэгчид 100% санал нэгдсэн. Мөн сумын болон багийн Засаг дарга нар МАН-н салбарын өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах , өөр аймаг сумын удирдлагуудтай отороор малчид өвөлжүүлэх гэрээг ойрын хугацаанд сайн хийх хэрэгтэй байна гэсэн санал гарлаа.

ӨНДӨРХАНГАЙ СУМ:

Хяналт үнэлгээний ажил: 1. ОНХС- ийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйлдвэрлэлийн хороолол руу цахилгаан дамжуулах агаарын шугам татах ажлын явцад ОНХС- ийн хяналтын зөвлөл хяналт хийлээ. 2. ЗДТГ- ын байцаагч нар, эмнэлгийн холбогдох албан тушаалтнууд, ИТХ- ын тэргүүлэгчидтэй хамтран үйл ажиллагаа ядуулж байгаа хүнсний дэлгүүрүүдийг сугалаа татаж сард 8 дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.



Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдөрт зориулан ахлах сургуулийн түүхийн багш Д. Батжаргалтай хамтран ахлах ангийн анги удирдсан багш нарт хэлмэгдүүлэлтийн тухай мэдээлэл өгч сургалт явууллаа. Анги удирдсан багш нар 09 сарын 04- 09- ний өдрүүдэд ахлах ангийн 8 бүлгийн 184 сурагчдад 1 цагийн хичээлийг зааж хэлмэгдүүлэлтийн талаар мэдээлэл өглөө. Төлөөлөгч Ц. Алтангэрэл сум хөгжүүлэх сангаас 6 сая төгрөгийн зээл 2013 онд 3 жилийн хугацаатай авч чацаргана тариалаад энэ жил анхны ургац 3 т жимс хураан авлаа.

Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210тоот

Утас :70453627

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:

http://uvs.khural.mn/

Facebook:

www.facebook.com/groups/uvs.ith

